



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 8 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 232

Улаанбаатар
хот

Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр
замын талаар авах зарим арга
хэмжээний тухай

Барилгын тухай хуулийн 32.1.5, Монгол Улсын хилийн тухай хуулийн 26.2.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:


1. Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын зориулалттай төмөр зам барьж 2019 онд ашиглалтад оруулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт тус тус даалгасугай.

2. “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-тай хамтарсан төрийн өмчийн тавин нэгээс доошгүй хувийн оролцоотой “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай.

3. “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийн нийт хувьцааны төрд ногдох 51-ээс доошгүй хувийг “Монголын төмөр зам” ТӨХК-д эзэмшүүлэхээр тогтсугай.

4. Улсын хилийн зурваст боомтын зориулалттай төмөр зам барих барилгын ажлын зөвшөөрлийг зохих журмын дагуу олгохыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Хилийн боомтын үндэсний зөвлөл (Х.Хүрэлбаатар)-д тус тус даалгасугай.

5. Боомтын зориулалттай 13 км төмөр замын суурь бүтцийн барилга угсралтын ажлыг 2018 оны 3 дугаар улиралд багтаан эхлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэд даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Зам, тээврийн хөгжлийн сайд

Ж.БАТ-ЭРДЭНЭ